



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**ТАЙЛАНГ ХҮЛЭЭН АВАГЧ:
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ,
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.ДАВААНЯМ**

2026 ОН

АГУУЛГА

Нэг. Зорилт.....	3
Хоёр. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд (Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн хэрэгжилт)	3
Гурав. Бүртгэлийн үйл ажиллагаа	9
3.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд :	9
3.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:	11
3.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:	13
3.4. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
Дөрөв. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа	16
Тав. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлт	19
Зургаа. Нэгжийн ил тод байдлын тайлан	19
(Байгууллагын цахим хуудас, санхүүгийн үйл ажиллагаа).....	19
Долоо. Сургалтын төлөвлөгөөг тайлагнах ажлын хүрээнд	21
Найм. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах (Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал).....	23
Ес. Идэвх санаачлага, шинэлэг ажил	27

2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. Зорилт

Тус хэлтэс нь 2026 онд хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө, “Алсын хараа-2050”, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон хэлтсийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, боловсронгуй болгох, зардал, шат дамжлагыг багасгах зорилт тавьж ажилласан.

Энэхүү зорилтын хүрээнд хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн хөтлөх, иргэн, хуулийн этгээдэд цахимаар үйлчилгээ үзүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай хүргэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн, тайлангийн хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хоёр. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд (Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн хэрэгжилт)

2.1. Бусад чиглэлээр байгууллагын удирдлага болон бусад газар, хэлтсээс өгөгдсөн үүрэг даалгаварын биелэлт:

Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, байгууллагын бодлого, стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө, үүрэг даавгарын биелэлтийг хангуулах чиг үүргийг хэрэгжүүлэн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, дээд шатны байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Хэлтсийн албан хаагчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, улсын бүртгэлийн хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын биелэлтийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг биелүүлэх, цаашид алдаа дутагдал гаргахгүй байх, хөтөлсөн бүртгэлийг тухай бүр цахимжуулах, бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах, төрийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор удирдах ажилтны шуурхай хурлаас өгсөн 3 үүрэг даалгавар, 16 зөвлөмж, чиглэлийг албан хаагчдад хамт олны хурлаар тухай бүр тогтмол танилцуулан, тайлант хугацаанд 7 удаа хурал хийсэн байна.

Хэлтсийн төрийн албан хаагчдын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тухайн албан хаагчийн жилийн ажлын зорилго, үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, хууль болон холбогдох журам, стандартад нийцүүлэн баталж, албан хаагч бүрийн чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод заасны дагуу тодорхой болгосон.

Мөн тус хэлтсийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн 01 дүгээр улирлын явцын үнэлгээг хийж Хууль зүй, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Хэлтсийн төрийн захиргааны 27 албан хаагчийн 2025 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч баталгаажуулан хууль тогтоомжийн хүрээнд хөрөнгө орлогын мэдүүлгийг тайланг байгууллагын ЭБАТ-д хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаа, түүний ач холбогдол, цаг үеийн мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллаж орон нутгийн радио, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэлтсийн улсын ахлах бүртгэгч, хяналтын улсын байцаагч нар 7 удаагийн ярилцлага, мэдээ мэдээлэл өгч ажилласан.

Монгол үндэсний уламжлалт “Цагаан сар”-ын баярын бүх нийтээр амрах өдрүүдэд ажлын байрны ашиглалт, хамгаалалт, аюулгүй байдалд хяналт тавих, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх үүрэг бүхий “хариуцлагатай жижүүр” томилон ажиллуулж тушаалын хэрэгжилтийг хангаж ажилласан.

Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгж, зөв шударгаар харьцаж иргэдээс ирсэн өргөдөл, хүсэлтийг тухай бүр шийдвэрлэн ажиллаж бүртгэлийн хөдөлгөөнт үйлчилгээний тоног төхөөрөмжийн бүрдлийг шинээр хангаж, тусгай хэрэгцээт, хөгжлийн бэрхшээлтэй, хүндэтгэн үзэх шалтгаантай өөрийн биеэр ирэх боломжгүй иргэдэд өргөдөл хүсэлтийн үндэслэн ар гэрт нь очиж тайлангийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ 1, иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ 26, нийт 27 иргэнд явуулын бүртгэлийн үйлчилгээг үзүүлээд байна.

Хэлтсийн “Эцэг эхийн зөвлөл”, “Өмч хамгаалах зөвлөл”, “Баримт бичиг нягтлан шалгах комисс” “Даргын зөвлөл”, Хуулийн этгээдийн бүртгэл хариуцсан улсын бүртгэгчид хураалгасан “Тамга, тэмдгийг устгах” ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.

Улсын бүртгэлийн Ерөнхий газраас 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 6/437 дугаар албан бичгээр ирүүлсэн Ёс зүйн хариуцлагыг сайжруулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг албан хаагчдад 2026.01.27-ны өдөр хамт олны хурлаар танилцуулан байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, үйлчилгээний чанар, стандарт, бүтээмжийг дээшлүүлсэн талаарх хэрэгжилтийн тайлан гаргаж хүргүүлсэн. Энэ ажлын хүрээнд сахилга ёс зүй, үйлчилгээний чанар стандартын сайжруулах төлөвлөгөө боловсруулан ажилласан.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу сургалтуудыг зохион байгуулж, байгууллагын соёлыг хэвшүүлэх, сахилга, дэг журмыг сахиулах, ажлын болон амралтын цагийн стрессийг даван туулах, хувь хүний хөгжил, хөдөлмөрийн зохион байгуулалт, төрийн албан хаагчийн ажил мэргэжлийн онцлог ур чадварыг оновчтой болгох талаар хэлтсийн албан хаагчдад мэдээлэл өгч мэдлэг, боловсрол, зөв ойлголтыг түгээх, манлайлах, ухамсар сэтгэлгээг нь хөгжүүлэх ажил хийсэн. Үүнд:

- “Стресс ба даван туулах арга зам” сэдэвт сургалтыг 2026.02.05,
- “Ашиг сонихрлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалтыг 2026.02.16,
- “Хувь хүний хөгжил, ажил амралтын харилцааны менежмент” сургалтыг 2026.02.26

Үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр 2026 оны 03 дугаар сард үйлчлүүлэгч 20 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан бөгөөд уг судалгаагаар үйлчилгээний хүртээмж сайжирсаныг дурдаж, иргэдийг ялгаварлахгүй, ижил, тэгш шударгаар үйлчлэхийг үйлчилгээний танхимд ажиллаж буй улсын бүртгэгч нарт анхааруулав.

Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангаж цахим халдлага зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021.01.14-ний өдрийн А/02 дугаар тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ыг мөрдлөг болгон албан хаагчдад танилцуулан, сургалт зохион байгуулсан.

Хэлтсийн төвийн сүлжээний хамгаалалтыг сайжруулж, галт хана (firewall)-тай Forti роутер шинээр байршуулсан.

Албан хаагчид ажлын бус цагаар болон цахим орчинд (Facebook, Twitter гэх мэт) байгууллагын нэр хүндэд сөрөг мэдээлэл түгээхгүй байх, албаны нэрийг хувийн зорилгоор ашиглахгүй байх, цаг ашиглалтыг сайжруулах, харилцааны соёлыг сахиж ажиллах талаар албан хаагчдад улсын ахлах бүртгэгч нар тасгийн хурлыг 15 удаа хийж, тухай бүр анхааруулан өдөр тутам хяналт тавьж ажиллаж байна.

Гадаад улс руу хувийн ажлаар зорчсон 1 албан хаагчийн гадаадад зорчсон хүсэлт, гадаадад зорчсон тухай илтгэх хуудсыг авч журмын дагуу Тамгын газарт мэдэгдсэн.

Хэлтсийн үйлчигээний зааланд албан хаагчдын ажиллах орчин, үйлчлүүлэгчдийн тав тух, сэтгэл ханамж зэргийг үнэлж дүгнэн, ажлын байрны нөхцөлийг сайжруулах хүрээнд “Улсын бүртгэлийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх” 134.498.000 (нэг зуун гучин дөрвөн сая дөрвөн зуун ерөн найман мянга) төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл боловсруулан, дэмжлэг хүсч аймгийн Засаг даргад албан тоотоор хүргүүлсэн.

Албан хаагчдын цагийн бүртгэлийг ERP цахим системээр бүртгэж, байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд 17 албан хаагчид чөлөөний хуудсаар чөлөө олгож, гадуур ажилласан 16 албан хаагчийн бүртгэлийг хөтөлж, хяналт тавин ажилласан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газраас ирүүлсэн 2/1834 албан бичгийн дагуу Монгол улсын тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/66 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам”-ыг үндэслэн 2026 оны 1, 2 дугаар улирлын байдлаар Улсын бүртгэлийн хэлтэст ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж тайланг Хууль зүй, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлсэн.

2.2. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр өгөгдсөн үүрэг даалгаварын биелэлт:

Иргэний улсын бүртгэлийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 3/297 дугаартай “Нэмэлт, өөрчлөлт, нөхөн бүртгэл шалгах тухай” албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд 2023 онд нэмэлт өөрчлөлт 921, нөхөн бүртгэл 54, 2024 онд нэмэлт өөрчлөлт 1105, нөхөн бүртгэл 250, 2025 онд нэмэлт өөрчлөлт 2233, нөхөн бүртгэл 196 бүртгэж мэдээллийн санд өөрчлөлтийг тусгаж ажилласан.

Ирүүлсэн чиглэлийн дагуу мэдээллийн санд бүртгэгдсэн бүртгэлийг нэг бүрчлэн шалгасан бөгөөд шалгах явцад 2023 оны цахимжуулаагүй төрөлтийн 26 бүртгэлийн маягтыг цахимжуулан, нөхөн бүртгэлд төрөлтийн 20, гэрлэлтийн 28, үрчлэлтийн 1 бүртгэлийн бүртгэсэн газрыг “Баян-Өлгий” гэж бүртгэснийг залруулан зөвтгөж зассан.

Иргэний улсын бүртгэлийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 3/999 дугаартай “Иргэний улсын бүртгэлийг баталгаажуулах тухай” албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд төрийн үйлчилгээг иргэнд чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэх, улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүртгэл баталгаажуулах эрхийг нэгжийн улсын бүртгэгчид шилжүүлэхтэй холбоотойгоор 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр “Иргэний улсын бүртгэлийг баталгаажуулахдаа анхаарах асуудал” сэдвээр сургалтыг хэлтсийн төвийн албаг хаагчдад танхимаар, сумдын улсын бүртгэгч нарт цахимаар зохион байгуулж, ирсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгон баталгаажуулалт хийх эрхийг 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс нээсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 2830 бүртгэлд өдөр тутмын хяналт тавин ажиллаж байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын нөхөн сонгууль болох Алтанцөгц, Ногооннуур сумдын ИТХ-ын тогтоолыг хүлээн авч мэдээллийн санд оруулан эх хувийн иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн.

Нөхөн сонгуультай холбогдуулан Иргэний улсын бүртгэлийн газраас 3/3079, 3/3576 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжүүдийн хүрээнд хийсэн ажлын илтгэх хуудсыг тухай бүр хэлтсийн даргаар хянуулан холбогдох газарт хүргүүлсэн.

Сонгуулийн тухай хуулийн дагуу Ногооннуур сумын ИТХ-аас сумын сонгуулийн хороог байгуулаагүй учраас тус суманд нөхөн сонгууль явагдахгүй болсон. Харин Алтанцөгц сумын 3-р баг буюу “Улаанхаргана” багийн 2-3-3 хэсгийн хорооны нэрсийн жагсаалтыг хуулийн хугацаанд гаргаж тус сумын сонгуулийн хэсгийн хороонд зохих хууль журмын дагуу хүлээлгэн өгсөн болно.

Цахим засаглалыг хөгжүүлэх замаар төрийн үйлчилгээ дижитал хэлбэрт эрчимтэй шилжиж байгаа энэ цаг үед улсын бүртгэлийн мэдээллийн сангийн цахимжуулалтыг нэмэгдүүлэх үнэн зөв байдлыг хангах ажлыг нэн яаралтай хийх ажлын хүрээнд байгууллагын Нэгдсэн архивын газрын даргын 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 6/4119 тоотой ирүүлсэн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь төрөлт, нас барсны, гэрлэсний хөрвүүлэлтийн алдааг засварлах ажлын үргэлжлүүлэн хийж байгаа бөгөөд тус аймагт харьяалалтай 5200 гаруй иргэний мэдээллийг эх нотлох баримттай тулган засварлах ажлыг өнгөрсөн оны 5 дугаар сараас эхлүүлж өнөөдрийн байдлаар нас баралт, гэрлэлтийн бүртгэлийг тулгах ажлыг дуусгаж, төрөлтийн бүртгэлийг архивын эх нотлох баримттай тулган мэдээллийн санг зөвтгөн ажиллаж байна.

Байгууллагын даргын 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/64 тушаалын дагуу 2020-2025 онд хийгдсэн иргэний улсын бүртгэлд хяналт шалгалт хийгдсэн ба уг шалгалтаар илэрсэн зөрчлийг шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр иргэний улсын бүртгэлийн газрын даргаас ирүүлсэн. Уг ажлын хүрээнд тухайн аймагт оршин сууж буй иргэдийн тоон мэдээллийг гаргаж (иргэний үндэс угсаа буруу бичигдсэн, бичигдээгүй байгаа гэх) зөрчлийг арилгах ажлын хүрээнд иргэдийн нэрсийг гаргаж

зөрчил арилгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн сумдын ЗДТГ-тай хамтран төрсөн болон нас барсан иргэдийн мэдээллийг тулган шалгах ажлыг хийж байгаа болно.

2.3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр өгөгдсөн үүрэг даалгаварын биелэлт:



Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газраас 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 4/498 тоот албан бичигт дурдсаны дагуу улсын бүртгэгч нар зарим бүртгэлийг эрхлэн хөтлөхдөө хууль, журмаар зохицуулсан харилцааны талаар нэг мөр ойлголт, ойлголтгүй, хуулийн хийдэл, зөрчилтэй, шийдвэрлэхэд бэрхшээлтэй байгаагийн улмаас хуулийн хэрэглээний зөрүүтэй байдал үүсэж байгаа байдалд тус хэлтсийн хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн эрхийн улсын бүртгэлийн тасгаас кейс, жишээ баримттайгаар 4 саналыг хүргүүлсэн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 5/588 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлдөг улсын бүртгэгч нарт тасгийн хурлаар танилцуулж, 2026.01.16-2026.01.20 хүртэлх хугацаанд улсын ахлах бүртгэгч түүвэрчилсэн байдлаар 50 бүртгэлийн хувийн хэргийн бүрдүүлэлт, дараалал, цахимжуулалт, бүртгэлийн хугацаа зэргийг нягтлан шалгаж биелэлтийг илтгэх хуудсаар холбогдох газарт хугацаанд хүргүүлэн ажилласан.


Мөн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 5/587 тоот албан бичгээр ирүүлсэн мэдэгдлийн дагуу 2026 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийг шинээр батлагдсан маягт загварын дагуу хөтөлж эхэлсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 4/556 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээллийг эд хөрөнгийн улсын бүртгэгч нарт танилцуулан албан бичигт зааснаар хууль хяналтын болон төрийн байгууллагаас ирсэн 95 албан бичигт хууль, журмын дагуу лавлагаа мэдээллийг үнэн зөв, гүйцэд гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.


Тайлангийн хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 4/1658, 4/2008, 4/1857, 4/2308, 4/3011, 4/3151, 4/3759, 4/2019 тоот албан бичгүүдээр ирүүлсэн зөвлөмж, чиглэлүүдийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлдөг улсын бүртгэгч нарт тасгийн хурлаар танилцуулж, дээрх чиглэлийн хүрээнд сургалт зохион байгуулж, холбогдох хууль, журмыг мөрдлөг болгон ажиллаж, улсын ахлах бүртгэгч мэргэжил арга зүйн удирдлагаар ханган өдөр тутмын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж хуулийн дагуу ажиллаж байна.



Мөн тус аймгийн тойргийн нотариатчидтай уулзалт зохион байгуулж цахим нотариатын “Зуучлалын модуль” системээр дамжуулан улсын бүртгэлийн мэдээллийн санд гэрээ, хэлцэл илгээх, бүртгэх талаар харилцан мэдээлэл солилцов. Тайлангийн хугацаанд 1 бүртгэлийг цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/77 тоот тушаалаар тус аймгийн Баяннуур, Булган, Сагсай, Ногооннуур сумын улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн бүртгэл хөтлөх эрх олгогдсон бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 11 сум, 1 тосгонд эд хөрөнгийн эрхийн бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байна.



Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг сумаас үзүүлсэн тоо (2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар)



Гурав. Бүртгэлийн үйл ажиллагаа


3.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд :

Тайлангийн хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/207 тоот тушаалаар шинээр батлагдсан “Иргэний улсын бүртгэл хөтлөх журам”-ыг мөрдлөг болгон Иргэний улсын бүртгэлд 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 11797 иргэн хамрагдсан. Үүнд:

Д/д	Үйлчилгээний нэр, төрөл	Тоон үзүүлэлт	
1	Төрсний бүртгэл	1008	
2	Хүүхэд үрчлүүлсний бүртгэл	19	
3	Овог, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл	27	
4	Эцэг, /эх/ тогтоосны бүртгэл	8	
5	Гэрлэсний бүртгэл	161	
6	Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл	22	
7	Нас барсны бүртгэл	231	
8	Иргэний үнэмлэх олголт	2029	
9	Үндэсний энгийн гадаад паспорт, түүнийг орлох бичиг баримтийн олголт	2271	
10	Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл	1822	
11	Шилжилт хөдөлгөөний бүртгэл	640	
12	Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл	818	
13	Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр гэрчилгээ дахин олголт	155	
14	Нөхөн бүртгэл	66	
15	Лавлагаа	Иргэнд	1865
		Албан хэрэгцээнд	147
		Хууль хяналтын болон төрийн байгууллагад албан тоотоор	508
НИЙТ		11797	

Харьцуулсан тоон үзүүлэлт

Хүснэгт 1



Тайлант хугацаанд 8331 бүртгэлийн 15920 хуудас материалыг цахимжуулсан байна.

Төрөлт, гэрлэлтийн гэрчилгээг гээгдүүлсэн болон гэмтээсэн, засвар өөрчлөлтийн бүртгэлийн дахин олголтоор төрөлтийн 147, гэрлэлтийн 8, нийт 155 иргэнд дахин гэрчилгээ олгов.

Тайлангийн хугацаанд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн 3 иргэний регистрийн дугаарыг, шүүхийн шийдвэрийг үндэслэн 3 регистрийн дугаар нийт 6 иргэний регистрийн дугаар өөрчилсний бүртгэлд бүртгэж иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажиллав.

Тайлангийн хугацаанд шүүхийн шийдвэр болон хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр үрчлэлт хүчингүй болсон 8 иргэний хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд бүртгэл хөтөлж, УБЕГ-т хүргүүлж хууль журмын дагуу иргэний цахим мэдээллийн санд үрчлэлт нь хүчингүй болсон.

Мөн гадаадын иргэн, харьяалалгүй хүний иргэний улсын бүртгэлийн чиглэлээр гэр бүлийн байдлын бүртгэлээс нийт 9 бүртгэлд иргэний өргөдлийг хүлээн авч хуулийн дагуу бүртгэсэн. Үүнд:

- Гадаадын иргэн, харьяалалгүй иргэний төрсний бүртгэл 5,
- Гэрлэлтийн бүртгэл 2,
- Эцэг (эх) тогтоосны 2 бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулан улсын бүртгэлийн гэрчилгээ олгосон болно.

Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд: 2026 оны эхний 5 сарын байдлаар нийт 3804 иргэн тоон гарын үсэг авснаас гар утасны Gsign app-д 3312, иргэний үнэмлэхэд 492 иргэн авсан байна.

Тоон гарын үсэг олголтыг нэгжээр харуулбал 2025.12.26-2026.05.03 хүртэлх нэгжийн тоон гарын үсэг олголтын тоон үзүүлэлт:

Хүснэгт 2


Аймаг	Сум	Киоск		Нэгж		Нийт
		Гар утасны Gsign app	Иргэний үнэмлэх	Гар утасны Gsign app	Иргэний үнэмлэх	
Баян-Өлгий	Хэлтэс			1335		1,335
	Алтай			3		3
	Алтанцөгц			67	1	68
	Баяннуур			221		221
	Бугат			4		4
	Булган			216		216
	Буянт			114		114
	Дэлүүн			198		198
	Ногооннуур			296		296
	Сагсай			146		146
	Толбо			151		151
	Улаанхус			207		207
	Цэнгэл	256	251	-		507
	Өлгий	23	240	75		338
Нийт		279	491	3,033	1	3,804

3.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг хууль журмын дагуу явуулж 2026 оны эхний хагас жилийн байдлаар дараахь ажил үйлчилгээг иргэдэд үзүүлсэн байна. Үүнд:

Д/д	Орлого, тэмдэгтийн хураамж нэр төрөл	Мөнгөн дүн /төгрөг/
1	Үйлчилгээний хураамжийн орлого	113.162.022
2	Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхээ худалдснаас оруулсан татварын орлого	356.661.458
3	Улсын тэмдэгтийн хураамж	5.589.221
Нийт 475.412.701 (Дөрвөн зуун далан таван сая дөрвөн зуун арван хоёр мянга долоон зуун нэг) төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.		

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний хөлс, тэмдэгтийн хураамж:




Тайлант хугацаанд биечлэн 5628 мэдүүлэг, онлайнаар 18 мэдүүлэг тус тус хүлээн авч хянан шийдвэрлэсэн.

№	Бүртгэлийн төрөл	тоо
1	Анхны бүртгэл	618
2	Өмчлөх эрх шилжих гэрээ	768
3	Барьцааны гэрээ	3542
4	Бүртгэлд өөрчлөлт оруулах	513

5	Лавлагаа, хуулбар	52
6	Хувийн хэрэг хаах	135
	Нийт	5628

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоон үзүүлэлт графикаар харьцуулж харуулбал:



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирсэн албан бичгээр эрх түдгэлзүүлсэн 78, эрх сэргээсэн 18 үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг цахим санд тусгасан байна. Түүнчлэн хөрөнгийн багцад тусгай тэмдэглэл 59 хийж ажилласан.


Архивт 618 хувийн хэргийг шинээр хүлээн авч, 5010 хувийн хэрэгт нөхөн бүрдүүлэлт баяжилт хийгдсэн. 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 37260 хувийн хэрэг архивт хадгалагдаж байна.

Хууль хяналтын байгууллагаас гаргасан албан хүсэлтийн дагуу эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн талаарх 95 лавлагаа мэдээллийг албан бичгээр хүргүүлэн ажилласан.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд эх нотлох баримтаас зөрүүтэй, алдаатай бүртгэгдсэн 36 үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн зөрчлийг арилгаж шийдвэрлэсэн.

Тасгийн өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж эд хөрөнгийн чиглэлээр 5400, хуулийн этгээдийн чиглэлээр 216 бүртгэлд өдөр тутмын хяналт тавьж, улсын бүртгэгчдийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан.

Хэлтсийн нэгжийн зохион байгуулалтаар төвийн 4 улсын бүртгэгч 2 нь мэдүүлэг хүлээн авах, 2 нь боловсруулалт хийх зарчмаар ажлын хуваарийн дагуу сар сараар ээлжлэх байдлаар ажлын зохион байгуулалтыг дотооддоо хийж ажиллаж байна.


БАТЛАВ
 ХЭЛТСИЙН ДАРГА  Д.МЯГМАРЖАВ
 ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
 ТАСГИЙН АЛБАН ХААГЧДЫН 2026 ОНЫ ЭХИЙН ХАГАС ЖИЛИЙН
 АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр

Д/д	Үйл ажиллагаа, арга хэмжээ	Хариуцаж албан хаагч	Хугацаа	Хяналт тавих албан хаагч
Нэг. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг				
1	Мэдүүлэг хүлээн авах Боловсруулалт хийх	Улсын бүртгэгч Х.Тилеубек, Х.Имашхан	1-р сар	Улсын ахлах бүртгэгч Ш.Еркинбек
2	Мэдүүлэг хүлээн авах Боловсруулалт хийх	Улсын бүртгэгч К.Ерке, Д.Нина		
3	Мэдүүлэг хүлээн авах Боловсруулалт хийх	Улсын бүртгэгч Х.Имашхан, Х.Тилеубек	2-р сар	
4	Мэдүүлэг хүлээн авах Боловсруулалт хийх	Улсын бүртгэгч Х.Имашхан, Х.Тилеубек	3-р сар	
5	Мэдүүлэг хүлээн авах Боловсруулалт хийх	Улсын бүртгэгч К.Ерке, Д.Нина	4-р сар	
6	Мэдүүлэг хүлээн авах Боловсруулалт хийх	Улсын бүртгэгч Х.Имашхан, Х.Тилеубек	5-р сар	
			6-р сар	

-00-

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн тоон үзүүлэлт /2026.05.25-ны өдрийн байдлаар/



Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлдөг улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн (еррс) цахим системд ажиллах, бүртгэл хөтлөх талаар цахимаар эрх зүйн чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулсан.

3.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 432 бүртгэл хөтөлсөн байна. Үүнд:

Д/д	Үйлчилгээний төрөл	Бүртгэлийн тоо
1	Шинээр бүртгэсэн хуулийн этгээд	161
	ХХК	100
	Төрийн бус байгууллага	20
	Хоршоо	28
	Боловсролын сургалтын байгууллага	1
	Нөхөрлөл	7
	Үйлдвэрчний эвлэл	5


2	Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл	194
3	Салбар	4
4	Дахин гэрчилгээ	39
5	Нэрийн баталгаажуулалт	103
6	Төрийн бус байгууллагын тайлан	4
7	Лавлагаа, хуулбар	45
8	Тамга, тэмдэг	27
9	Хориг тавьсан	1

Тамга тэмдгийн хяналтын **188** дугаар олгож, оноосон нэр өөрчлөгдсөн, мэдээлэл зөрсөн, хуучирсан болон ашиглалтын шаардлага хангаагүйн улмаас дахин тэмдэг хийлгүүлэх хүсэлтээр **24** тэмдэг хурааж авсан.

Сар бүр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоон мэдээ гарсны дараа архивчтай мэдээгээ тулган нягталж байгаа. 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар **3551** хувийн хэрэг архивд хадгалагдаж байна.

**УЛСЫН БҮРТГЭГЧ НАРЫН БҮРТГЭСЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
БҮРТГЭЛ СУМ ТУС БҮРЭЭР ТООН ҮЗҮҮЛЭЛТ**

Д/д	Сумын нэр	Бүртгэгчийн нэр	Бүртгэлийн тоо
1	Алтай	Д.Болормаа	9
2	Алтанцөгц	А.Бадамсүрэн	2
3	Баяннуур	Н.Нурдыхан	12
4	Бугат	С.Лена	3
5	Булган	С.Күмисжан	3
6	Буянт	С.Жаргалсайхан	2
7	Дэлүүн	С.Рысбай	7
8	Толбо	Д.Тойжан	4
9	Улаанхус	Б.Бахытгүл	3
10	Цагааннуур	Б.Айсауле	3
11	Өлгий	А.Алтангул	384
НИЙТ			432



Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоон үзүүлэлт

Хуулийн этгээдийн цахим мэдээллийн санд зөрүүтэй бүртгэгдсэн, тамга, тэмдгээ үрэгдүүлсэн 4 хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч дүгнэлт гаргуулахаар хяналтын улсын байцаагчид шилжүүлж, дүгнэлт гаргуулан бүртгэсэн.

Тайлант хугацаанд шинээр болон нэмэлт өөрчлөлтөөр бүртгэсэн 432 бүртгэлийн бүрдүүлбэр, бичиг баримтыг зохих журмын дагуу цахимжуулж архивт хугацаанд нь шилжүүлсэн.

Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой мэдээ, тайлан, судалгааг тогтоосон хугацаанд гаргаж удирдлагад танилцуулан ажилласан.

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг улсын бүртгэлд бүртгүүлэх талаар иргэдэд цахимаар 3 удаа мэдээ мэдээлэл хүргэсэн.

Мөн төрийн бус байгууллагын тайлан, санхүүгийн тайлангаа гаргаж холбогдох байгууллагад илгээгээгүйн улмаас улсын бүртгэлээс хасагдах жагсаалтад орсон 5 хуулийн этгээдийн сэргээх хүсэлтийг авч уламжилсны дагуу дахин сэргээлгэсэн.


Төрийн бус байгууллагын тайланг хэрхэн хүргүүлэх талаар, хуульд заасан тайлан гаргах эцсийн хугацааны талаар орон нутгийн радиод 1 удаа ярилцлага мэдээлэл өгсөн. Түүнчлэн хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх эрх нээлгэсэн сумдын улсын бүртгэгч нарт хуулийн этгээдийн бүртгэлийн талаар 1 удаа сургалт зохион байгуулсан.

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 27 албан тоот хүлээн авч хуульд заасан хугацаанд хариу хүргүүлж ажилласан.

3.4. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа

Тус хэлтсийн хяналтын улсын байцаагч нар нь 2026 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор нийт 17857 бүртгэлд байнгын хяналт тавьж шалгасан байна. Үүнээс:

- Иргэний улсын бүртгэлийн 11797 бүртгэл,
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 5628 бүртгэл,
- Хуулийн этгээдийн 432 бүртгэл,
- Улсын бүртгэлийн архивын чиглэлээр 1514 бүртгэлийн эх нотлох баримтад байнгын хяналт тавьж шалгасан.



Илрүүлсэн зөрчлийг ангилж үзвэл:


- Иргэний улсын бүртгэл 16,
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 12,
- Хуулийн этгээдийн улсын бүртгэл 10,
- Архивын зөрчил 1 тус тус илрүүлсэн.

Илрүүлсэн зөрчлийн хүрээнд 34 хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 56 иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд холбогдох эрх зүйн нөхцөл байдлыг эх нотлох баримтыг үндэслэж тогтоон шийдвэрлэж, зөрчлийг арилгасан.

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт 2, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 1, гүйцэтгэлийн хяналт шалгалт 10 хийсэн.

Тайлангийн хугацаанд 32 иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг хүлээн авч, хууль журмын дагуу хянан шалгаад хариу өгсөн.

Мөн Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн иргэн, хуулийн этгээдийг хуулийн тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй, хууль, журам зөрчсөн 206 иргэн, 5 хуулийн этгээдийн зөрчлийг Зөрчлийн тухай Монгол улсын хуулийн холбогдох заалтыг үндэслэн хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж, нийт 6.990.000 (зургаан сая есөн зуун ерөн мянга) төгрөгийн хүү торгууль оногдуулж, Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлт хангуулан ажилласан байна.



Тав. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа

Иргэний бүртгэлийн баримт бичгийн архивт 2026 оны эхний хагас жилийн байдлаар иргэний гэр бүлийн байдлын болон иргэний бүртгэлийн чиглэлээр 8 төрлийн бүртгэлд:

- ИУБ-11 маягт төрөлт 1008,
- ИУБ-12 маягт үрчлэлт 19,
- ИУБ-13 маягт овог, эцэг (эх)-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 27,
- ИУБ-14 маягт эцэг (эх) тогтоосны бүртгэл 12,
- ИУБ-15 маягт гэрлэлтийн бүртгэл 465,
- ИУБ-16 маягт гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 22,
- ИУБ-18 маягт нас баралт ширхэг 231,
- Иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдсан ИУБ-31 маягт 2029, нийт 1503 ширхэг маягтуудыг журмын дагуу хүлээн авч архивт хувийн хэрэг хүлээн авах дэвтэрт бүртгэж, хүлээн авах тамга дарж, баримтыг төрөлжүүлэн ангилан ялгалт хийж хувийн хэрэгт баяжуулалт хийсэн.

ХААТР-22 маягт 1018 ширхэг маягт хүлээн авч хадгалах журмын дагуу иргэний архивт хадгалагдаж байна. Өнөөдрийн байдлаар иргэний баримтын архивд 177979 хувийн хэрэг хадгалагдаж байна.

Бусад аймаг нийслэлээс шилжиж ирсэн, биеийн давхцахгүй өгөгдөлд хамрагдсан, нас барсан, гэрлэсэн, төрөлт бүртгүүлсэн иргэний нийт 652 гаруй маягтыг хүлээн авч, бүртгэж хүлээн авах тэмдэг дарж байршуулсан.

2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр баримт бичиг нягтлан шалгах комисс (ББНШК)-оор “Баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт”-ын дагуу хадгалах хугацаа нь дууссан, мэдээлэл лавлагаанд ашиглагдахгүй болсон баримтыг цаашид архивт хадгалах шаардлагагүй гэж үзэж баримт бичгийн жагсаалт үйлдэн Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 11-р багт байрлах “Жорга” ХХК-ний уурын зууханд нийт 71 бүртгэлийн дэвтэр, 348 ширхэг хадгаламж нэгж устгалд оруулж, биелэлтийг ерөнхий газарт хүргүүлж ажилласан.



Мөн түүнчлэн байгууллагын архивыг цэгцлэх явцад “Баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт”-аар хадгалах хугацаа нь дууссан, мэдээлэл лавлагаанд ашиглагдахгүй болсон баримтын жагсаалтыг гаргаж, 41 ширхэг хадгаламжийн нэгжийг устгалд оруулсан болно.

Аймгийн Архивын хэлтэст хүсэлт явуулж мэргэжилтнээс зөвлөгөө авч, байгууллагын архивыг өөр өрөөнд нүүлгэн бүх хадгаламжийн нэгжийг “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт, Төрийн архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын дагуу хадгаламжийн нэгжид тоо бүртгэл үүсгэж “байнга”, “70 жил”, “түр хадгалах” хадгаламжийн нэгжийг ялгаж, сэргээн засаж, цэгцэлж байгаа болно. Одоогийн байдлаар энэхүү ажлын хэрэгжилт 80%-тай явж байна.

Өмнө нь



Дараа нь



Тайлангийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт 618 хувийн хэргийг шинээр хүлээн авч, 5628 хувийн хэрэгт нөхөн бүрдүүлэлт, баяжилт хийсэн. Өнөөдрийн байдлаар тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 37260 хувийн хэрэг, хуулийн этгээдийн бүртгэлийн 3551 хувийн хэрэг зохих журмын дагуу архивт хадгалагдаж байна.

Мөн 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдөр архивуудын өрөө тасалгаанд мэргэжлийн байгууллагаар хортон шавж, мэдрэгчийн устгал, ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэсэн.



Байгууллагын даргын А/177 дугаар “Улсын бүртгэлийн байгууллагын брэндбүүкийн загвар батлах тухай” тушаалын хэрэгжилтийг хангаж архивын хувийн хэргүүдийг хаягжилтийг шинэчилсэн.



2026 оны 5 дугаар сарын 20-ноос Байгууллагын даргын 107 дугаар тушаалын дагуу эд хөрөнгийн архивын тооллого эхэлсэн бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 21945 хувийн хэрэг тоолж, тооллогын явц 60%-ийн гүйцэтгэлтэй байна.

Зургаа. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлт

ХЗДХЯ-наас 2022 оны 3/5952 дугаар албан бичгээр "ХЗДХЯ-ны салбарын цахим архив, цахим албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем" ERP E-mongolia систем болон Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/66 дугаар тушаалаар "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам"-д холбоотой өргөдөл гомдлын сургалтад хамрагдсан.

Тайлангийн хугацаанд хууль хяналтын болон бусад байгууллагуудаас 689 албан бичиг хүлээн авсан байх ба нийтдээ 598 албан бичиг гадагш явуулсны 516 нь хууль, хяналтын байгууллага болон бусад байгууллагад хүргүүлсэн хариутай албан бичиг болно.

Мөн хэлтсийн даргын "А" тушаал 11, "Б" тушаал 6, нийт 17 тушаалыг гарган холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Оны эхнээс иргэдээс нийт 27 өргөдөл хүлээн авч, холбогдох албан хаагч нарт хуваарилан хуулийн хугацаанд шийдвэрлүүлсэн.

Дээрх 27 иргэний өргөдлөөс 26 өргөдлийг шийдвэрлэж, бусад байгууллагад шилжүүлсэн 0, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 0, хугацаа болоогүй 1 иргэний өргөдөл хяналтад байна.

"Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам"-ын дагуу 1, 2 дугаар улирлын өргөдөл гомдлын тайланг гарган, дүн шинжилгээ хийж хүргүүлсэн.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг ангилж үзвэл иргэний бүртгэлийн чиглэлээр иргэний баримт бичгийн зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол ихэнх хувийг эзэлж байгаа ба иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж байна. Мөн түүнчлэн иргэдийн өргөдөл, гомдлыг хэлтсийн 7042-7810, 7042-3745 дугаарын утас, bayan-ulqii@burtgel.gov.mn цахим хуудсаар тус тус хүлээн авч ажиллаж байна.

Долоо. Нэгжийн ил тод байдлын тайлан (Байгууллагын цахим хуудас, санхүүгийн үйл ажиллагаа)

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан "Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам", Хууль зүйн сайдын 2012 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан "Хууль зүйн салбарын нээлттэй бодлогын баримт бичиг", Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтээр тогтоосон ил тод нээлттэй байдлыг мэдээллийн цахим хуудсанд бүрэн байршуулж, олон нийтийг мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.


Тус хэлтсийн <https://bayan-ulgii.burtgel.gov.mn/> цахим хуудсанд тайлант хугацаанд иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэл, бүртгэлийн үйл ажиллагааны талаар 41 мэдээлэл байршуулж, олон нийтэд түгээх зорилгоор мэдээллийг фото зургийн хамт олон нийтийн социал сүлжээ буюу <https://www.facebook.com/bayanulgii.burtgel> фэйсбук пэйж хуудсаар мэдээллийг давхар түгээж ажиллаж байна. Үүнээс гадна УБЕГ-аас гаргасан аливаа шторк, мэдээллүүд, цахимаар бүртгэлийн үйлчилгээ авах зэрэг мэдээллийг тухай бүр байршуулан албан хаагч бүр шэйр хийх байдлаар мэдээллийг түгээн ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 4200 дагагчтай бөгөөд 2026 оны эхний хагас жилд социал хуудсаар дамжуулан 68 бүртгэлтэй холбоотой мэдээллийн түгээлт хийгдсэн байна.

Цахим хуудасны “танилцуулга” цонхонд нэгжийн бүтэц, албан хаагчдын мэдээлэл, “ил тод” цонхонд хүний нөөцийн ил тод байдал, шилэн данс, хурал, сургалт, семинарын зар, улирал, жилийн тайлан, “хэрэглэгч таньд” цонхонд түгээмэл асуулт, хариулт, нээлттэй ажлын байрны зар, өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдал, сар бүрийн тоон мэдээ, “холбоо барих” цонхонд байгууллагын хаяг, байршил, ажиллах цагийн хуваарь, иргэдийг хүлээн авах цаг, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах утасны дугаар, шуудангийн хаяг зэргийг нээлттэй байршуулсан. <https://bayan-ulgii.burtgel.gov.mn/sar-buriin-toon-medeelel>

“Нүүр” хуудсанд цаг үеийн мэдээ, мэдээлэл, видео мэдээллүүд, аймгийн танилцуулга, түүх болон дурсгалт газрууд, фото зургийн цомог, мөн аймгийн далбаа, газрын зураг зэргийг бүрэн оруулсан.

“Баннер” хэсэгт төрийн үйлчилгээний E-mongolia цахим систем, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн лавлагаа, үйлчилгээ авах Burtgel.mn систем, хуулийн этгээдийн оноосон нэр олголтын систем, авлигыг мэдээллэх 110 утас болон бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 зэрэг баннерүүдийг байршуулсан.

Цахим хуудасны “хөл” хэсэгт бусад аймгуудын холбоос болон хэлтсийн Google map дахь газрын байршлыг харуулсан болно.



Шил ажиллагааны <https://shilen.gov.mn/home> цахим хуудсанд улирал бүр:

- Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 18 үзүүлэлт,
- Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 7 үзүүлэлт,
- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 29 үзүүлэлт,
- Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараахь мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал 6 үзүүлэлтийг тухай бүр цахим хуудасны холбоос, файл

зургийн хамт хавсаргаж оруулсан. 2026 оны 1-р улиралд 91,34%-иар үнэлэгдсэн.

Санхүүгийн чиглэлээр:

Тус хэлтэс нь батлагдсан төсвийн хүрээнд хяналттай үр ашигтай, хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлэн ажиллаж байна. 2026 оны эхний 5 сарын байдлаар улсын төсвөөс 601.333.500 төгрөг, нэмэлт санхүүжилтээр аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 3.000.000 төгрөг, АНСДИТХ-ын нөхөн сонгуулийн ажлаар 4.879.000 төгрөг нийт 609.212.500 төгрөгийн санхүүжилт авснаас 600.304.275 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан нь нийт төсвийн 98.5% байна.

Эхний 5 сард 38.750.000 төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй байсан ба тайлант хугацаанд 94.859.642 төгрөгийн орлого оруулж, 90.228.495 төгрөгийг Сангийн яам улсын төсөвт шилжүүлсэн ба орлогын төлөвлөгөөгөө 144%-иар давуулан биелүүлсэн. Хэлтсийн 2027 оны төсөв, 2028-2029 оны төсвийн төсөөллийг тооцоо судалгаатай гарган дээд газарт хүргүүлсэн болно.

Сар бүрийн 02-ны өдрийн дотор төсвийн гүйцэтгэлийн тайлан, өглөг, авлага, нэр данс зөрүүгийн тайлан, санхүүгийн сарын мэдээ, үнэт цаасны зарцуулалт, үлдэгдэл, иргэний үнэмлэхийн орлогын тайлангуудыг ерөнхий газарт тогтмол хүргүүлэн ажиллаж байна. Түүнчлэн ХАОАТ, НДШ-ийн тайлангуудыг хуулийн хугацаанд гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Хэлтсийн 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэж “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох дансны мэдээллүүдийг тухай бүр 45, сар бүр 20, жил бүр байршуулах 3 мэдээллүүдийг тус тус хуульд заасан хугацаанд оруулж ажиллаж байна.

Төсөв, санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангах, байгууллага, иргэдэд нээлттэй байлгах ажлын хүрээнд байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудсанд 2026 оны төсөв, орлого, зарлага, төсвийн байгууллагын санхүүжилтийн сарын мэдээг хуульд заасан хугацаанд байршуулсан.

2026 оны 1 дүгээр улирлын тайланг e-accounting.mojha.gov.mn шинэ программаар гарган дээд газарт хүргүүлсэн. Төрийн өмчийн Umch.sgov.mn программд хөрөнгийн бүртгэл, өмчийн хөдөлгөөн, өөрчлөлтийг болон 3 талаас харуулсан фото зургийг нэг бүрчлэн авч оруулсан.

Найм. Сургалтын төлөвлөгөөг тайлагнах ажлын хүрээнд

Албан хаагчдын бүтээмж, мэдлэг чадварыг дээшлүүлэх, сэтгэл ханамжтай, хариуцлагатай ажиллуулах зорилтын хүрээнд 2026 оны сургалтын төлөвлөгөөний саналыг авч 2026 оны 03 дугаар сарын 18-ны батлуулсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас болон аймгийн ЗДТГ, бусад байгууллагаас зохион байгуулсан 12 удаагийн сургалтад хэлтсийн дарга болон холбогдох албан хаагчид хамрагдсан байна.

Төрийн албаны ерөнхий зөвлөлөөс долоо хоног бүрийн “пүрэв” гараг бүр зохион байгуулагддаг “7:4:10” сургалтад хэлтсийн албан хаагчид тогтмол хамрагдаж байна.

2026 оны 02 дугаар сарын 05-ны өдөр “Стресс ба түүнийг даван туулах арга зам” сэдэвт сургалт, 02 дугаар сарын 16-ны өдөр Прокурорын газраас “Түгээмэл үйлдэгдэж буй гэмт, хэрэг, зөрчлийн ялгаа” “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалт, 02 дугаар сарын 23-ны өдөр “Хувь хүний менежмент, ажил амралтын менежмент ба стресс” сэдэвт сургалт, мөн 02 дугаар сарын 28-ны өдөр Баян-Өлгий аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч С.Өмирбек “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Авлига, албан тушаалын гэмт хэрэг” сэдвийн хүрээнд тус хэлтсийн албан хаагчдад мэдээлэл өгч сургалт зохион байгуулав.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлтийн цогц аян-2026” аяны хүрээнд Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн М.Гүлия “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх нь” сэдвээр мэдээлэл өгч сургалт зохион байгуулсан.



Сургалтад хэлтсийн албан



хаагчид танхимаар, сумдын улсын бүртгэгчид цахимаар оролцож ХАБЭА-ийн мэдлэг, осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллах, эрүүл мэндээ хамгаалах, стрессгүй орчинд ажиллах чиглэлээр мэдлэгээ дээшлүүлсэн үр дүнтэй сургалт болсон.



Хэлтсийн “Эцэг эхийн зөвлөл”-өөс “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдэвт сургалтыг Хүүхэд гэр бүр бүлийн хөгжил хамгааллын газртай хамтран зохион байгуулав.

Дотоод сургалтууд:

Аймгийн 11 сум, 1 тосгонд хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг хөтөлдөг улсын бүртгэгч нарт хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ш.Еркинбек, хуулийн этгээдийн улсын бүртгэгч А.Алтангул, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Д.Нина нар бүртгэл хөтлөхөд анхаарах асуудлын талаар сургалт зохион байгуулсан.

Мөн сумдын улсын бүртгэгч нарт “Цахим архиваас лавлагаа олголт”-ын талаар сургалтыг 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж, мэдээлэл өгсөн.



Ес. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах (Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал)

Аймгийн ЗДТГ, болон бусад төрийн байгууллагатай нягт хамтран ажиллаж, холбогдох тайлан мэдээг хүргүүлэн ажилласан ба төрийн болон хууль хяналтын байгууллагад лавлагаа мэдээллийг түргэн шуурхай хүргүүлэн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн хэлтэс, архивын тасгийн барилга угсралтын ажлын төсвийг шинэчлэх боловсруулах шаардлагын хүрээнд аймгийн Засаг даргад холбогдох хүсэлтийг хүргүүлж, орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.

Уг ажлын хүрээнд 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Барилгын зураг төслийн “ББСМО” ХХК-тай зураг төсөв шинэчлэн боловсруулах гэрээ байгуулж, 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдөр барилгын ажлын шинэчилсэн төсвийг хүлээн авсан. Шинэчлэн боловсруулсан зураг төсөлд холбогдох магадлал хийгдэж экспертүүдийн дүгнэлт гарсан болно.

Түүнчлэн хэлтсийн УАЗ Hunter 0870ХОУ улсын дугаартай автомашины засвар үйлчилгээнд шаардагдах хийх 3.0 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлэн засвар үйлчилгээний ажлыг зохион байгуулсан.




Аймгийн Засаг дарга Е.Зангар хэлтэс, агентлагийн дарга нар болон сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах 2026 оны үр дүнгийн гэрээ байгуулсан бөгөөд энэхүү гэрээ нь Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймаг, сумын хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангахад чиглэж байна.

Мөн гэрээнд талуудын хүлээх үүрэг, улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт, төлбөрийн нөхцөл, хэрэгжилтийг дүгнэх, үнэлэх журмуудыг тусгаж, хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг салбар бүрээр тодорхойлсон юм.



Аймгийн Засаг даргаас баталсан удирдамжийн дагуу “Хуульчийн ПРО БОНО” өдөрлөг болон хууль сурталчлах “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг аймгийн төв талбайд 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан. Өдөрлөгт улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид идэвх санаачилгатай оролцож, 10 иргэнд тоон гарын үсэг олгож, 1 иргэнд хуулийн этгээдийн нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн. Иргэний улсын бүртгэл 25, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 40, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 33 нийтдээ 98 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч, улсын бүртгэлийн талаарх 20 гарын авлага тараасан.

Монгол Улсын Засгийн газар, Жендерийн үндэсний хорооноос Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан жил бүрийн 03 дугаар сарын 01-ээс 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл үндэсний хэмжээнд уламжлал болгон зохион байгуулдаг “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ” аянд нэгдсэн.



Алтанцөгц, Ногооннуур, Бугат, Сагсай сумдын улсын бүртгэгчид сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэгт орж, ЗДТГ-ын мэргэжилтнүүдийн хамт төрийн үйлчилгээ болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар багийн иргэдийг мэдээ, мэдээллээр ханган цаг үеийн үйл ажиллагааны талаар газар дээр ажилласан.

Иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх үйлчилгээнд байгууллагуудын дундын мэдээлэл солилцох, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, цахим нотариатын "Зуучлалын модуль" системээр дамжуулан улсын бүртгэлийн мэдээллийн санд гэрээ, хэлцэл илгээх, бүртгэх талаар аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, тойргийн нотариатч нартай уулзалт зохион байгуулж, харилцан мэдээлэл солилцов.



Улсын бүртгэгч түр эзгүй байгаа Цэнгэл суманд 2026 оны 03 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд ажиллаж иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 69, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 13, нийт 82 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, 50 гаруй иргэнд улсын бүртгэлийн талаар заавар, зөвлөгөө өгч ажиллав.



"Наурыз 2026" баярын арга хэмжээний үеэр аймгийн төв талбайд гэр барих ажил, мөн "Бэр буулгах" ёс заншлыг ард иргэдэд сурталчлах ажлуудыг орон нутгийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.



2026 оны 1,2 дугаар улирлын Төрийн албан ерөнхий шалгалтад оролцох иргэдийн мэдээллийг "Хур" системтэй тулган баталгаажуулах, нягтлан шалгах ажилд аймгийн "Төрийн албаны салбар зөвлөл"-тэй хамтран ажилласан.


Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх “Жендерийн дэд салбар зөвлөл”-ийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний дагуу албан хаагчдыг “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг”-т хамруулав.

Уг эрүүл мэндийн үзлэгт тус хэлтсийн 24 албан хаагч 6 үзүүлэлтээр үзлэг, шинжилгээнд хамрагдаж, зөвлөгөө авсан. Үүнд:

- Цусны шинжилгээ өгөх (халдварт өвчин байгаа эсэх болон сахарын хэмжээг тодорхойлох)
- Зүрхний бичлэг хийлгэх
- ЭХО
- Дотрын эмчийн үзлэг, зөвлөгөө
- Мэдрэлийн эмчийн үзлэг
- Эмэгтэйчүүдийн үзлэг
- Сэтгэл судлалын тест бөглөж, зөвлөгөө авах зэрэг үзлэг, үйлчилгээнүүд багтсан байна.



Мөн “Sano Dental Clinic”-тай хамтран “Шүд эрүүл бол бие эрүүл” сургалт зохион байгуулж, албан хаагчдын хүүхдүүдэд шүдний үзлэг хийж, урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгч ажиллав.



Арав. Идэвх санаачлага, шинэлэг ажил

Хүний эрхийг дээдлэх, хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт хүний эрхийг хангах, иргэдэд төрийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх зорилгоор “Тусламжийн хонх”-ыг улсын бүртгэлийн хэлтсийн үүдэнд байршуулсан.



Уг “тусламжийн хонх”-ны дуудлагаар 2 иргэнд тоон гарын үсэг, 1 иргэнд гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн. Мөн хэлтсийн үйлчилгээний зааланд байгаа харааны бэрхшээлтэй иргэнд зориулсан нүдний шилийг шинээр сольж, гарын авлагыг брайл үсгээр бэлтгэж байршуулсан.

Баян-Өлгий аймгийн хэмжээнд ИТХ-аас зохион байгуулсан “Авлигын эрсдэлээ өөрсдөө тодорхойлъя” сэдэвт контент бүтээх аянд “нас барсны бүртгэл”-ийг хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүйгээс үүсэх зөрчил, эрсдэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэдэвт контент бүтээж, “Шилдэг контент”-ээр шалгарч “Тэргүүн байр”-нд шалгарсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалан нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, иргэдийн байгаль орчны боловсрол, оролцоог нэмэгдүүлэх зорилготой “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тус хэлтсийн албан хаагчид 2026 оны 05 дугаар сарын 16-ны өдөр “Мод

тарих үндэсний өдөр” арга хэмжээг зохион байгуулж, "Ногоон хашаа"-нд 100 ширхэг мод тарьж суулгалаа.



Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2026 оны А/43 захирамжийн дагуу зохион байгуулагдаж буй “Өглөөний дасгал”, “Өглөөний алхалт” сарын аянд тус хэлтсийн албан хаагчид идэвхтэй оролцож 2 дугаар байр эзлэв.



Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Засаг даргын 2026 оны 1/102 тоот захирамжийн дагуу Өлгий хотын орох гарах чиглэл болон 3 замын уулзвараас “Түмэн” хүнсний дэлгүүр хүртэл хуваарьт газарт их цэвэрлэгээ хийж цэвэрлэн, хог хаягдлыг ачиж хогийн нэгдсэн цэгт буулгаж, аймаг орон нутгийн олон нийтийн ажилд идэвхтэй оролцлоо.



Хөгжлийн бэрхшээлтэй болон хүндэтгэн үзэх шалтгаантай өөрийн биеэр ирэх боломжгүй иргэнд зөөврийн тоног төхөөрөмжөөр гэрт нь очиж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ 1, иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ 26 нийтдээ 27 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.



ТАЙЛАН ГАРГАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.МЯГМАРЖАВ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

Х.АМАНГҮЛ